



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/125

Баян-Адарга

Г 7
Тээврийн хэрэгслийн татвар хураалт,
техникийн үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны А/12 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг 2026 оны 06 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Н.Ганбат (Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга О.Жаргалцэцэг (Татварын улсын байцаагч)
Гишүүд Г.Жавзмаа (Жаргалант багийн засаг дарга)
М.Нямдорж (Дуурлиг багийн засаг дарга)
Г.Намсрай (Сайхан багийн засаг дарга)
Н.Цолмонбаяр (Адарга багийн засаг дарга)
Г.Гомбосүрэн (Цагдаа)

3.Авто тээврийн хэрэгслийн үзлэгийг өөрийн нутаг дэвсгэрт байгаа бүх тээврийн хэрэгслийн бүртгэл судалгааны дагуу бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Техникийн үзлэгийн өмнө авто тээврийн хэрэгслийн албан татвар хураах ажлыг татварын улсын байцаагч (О.Жаргалцэцэг)-т даалгасугай.

5.Хуваарьт өдөр хэв журам сахиулах, авто тээврийн болон агаарын бохирдлын төлбөрөө төлөөгүй тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахгүй байхыг Хэсгийн төлөөлөгч, дэслэгч (С.Батсайхан), Цагдаагийн дэд ахлагч (Г.Гомбосүрэн) нарт үүрэг болгосугай.

6.Авто тээврийн хэрэгслийн үзлэгийн үйл ажиллагааны дүнг 2026 оны 06 дугаар сарын 30-ны дотор танилцуулахыг комиссын дарга (Н.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  ОЛХАГВАДОРЖ

